ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДОА-2020/13/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он


Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 7000-3775 Цахим хаяг: edi_7855@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НӨАТТХ | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль |

Агуулга

**Аудитын гэрчилгээ** ....................................................................3
2.1. Оршил ....................................................................5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....................,..5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ................................5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .................................5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ....................................................................6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ...................6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .......................................6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....................................................................6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ....................................................7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .................................................8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .........9
2.12. Шилэн дансны мэдээлэл ....................................................................9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ...................9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ....................................................................9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ....................................................................10
3.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ............................................................11
3.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .........................................................12
3.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ................................................................14
3.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан ..................................15
3.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..........................................................16

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ОТГОНГЭРЭЛ ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

**2.1.** Оршил

Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал С.Отгонгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

**2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 13–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

**2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорнод аймгийн Булган сумын ерөнхий боловсролын сургууль эрхэм зорилгоо “Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих” гэж тодорхойлон ажилласан байна.

Дорнод аймгийн Булган сумын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх
- хүүхдийн хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

**2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорнод аймгийн Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Булган сумын ерөнхий боловсролын сургууль санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа AXPLORER программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

**2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 34 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 419,379,2 төгрөгөөс тооцон 6,290.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

**2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Дорнод аймаг дахь Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,498.1 мянган төгрөгөөр буюу 1,3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 19,064.7 | 26,992.7 | 7,928.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,310,144.2 | 1,356,790.1 | 46,645.9 |
| Элэгдэл | -74,174.8 | -145,246.8 | -71,072.0 |
| **Нийт хөрөнгө** | **1,255,034.1** | **1,238,536.0** | **-16,498.1** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | **1,255,034.1** | **1,238,536.0** | **-16,498.1** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,255,034.1** | **1,238,536.0** | **-16,498.1** |

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аж ахуйн материал дансанд хандиваар 2,274.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, батлагдсан төсвөөс 5,654.0 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр дээврийн засвар 10,000.0 мянган төгрөг, халаалтын тогооны засвар 29,326.1 мянган төгрөг, хяналтын камер 3,600.0 мянган төгрөг, УИХ-ын гишүүн Х.Болорчулууны санхүүжилтээр 1,000.0 мянган төгрөгийн ном, батлагдсан төсвөөс 2,719.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Өглөг, авлагын данс үлдэгдэл байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 16,498.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүнгээс шалтгаалжээ.

**2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 356,471.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 312,578.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжих тусгай зориулалтын шилжүүлгээр, 25,500.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 356,471.0 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 29,326.1 мянган төгрөгийн халаалтын тогооны засварын ажлын санхүүжилт хийгдэж, батлагдсан зураг, төсвийн дагуу засварын ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна.

**2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 39 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 39 эрсдэл тодорхойлж нийт 39 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 26,004.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад 2,274.0 мянган төгрөгийн залруулга, 23,730.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.Үүнд:

1.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Нийт худалдан авалтын 39.0 хувь буюу 15.8 сая төгрөг нь татварын нэгдсэн цахим хуудас дахь ибаримт системд бүртгэгдээгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн *үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт ”Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2.Бараа материалын данстай холбоотой асуудал

Бараа материалын дансанд бүртгэлтэй 7,9 сая төгрөгийн хөрөнгийг тоо ширхэг үнийн дүнтэй нь тулган баталгаажуулж, хөрөнгийн тооллогонд хамруулаагүй, “бараа” гэсэн нэрээр тайланд тусгагдсан байна. Энэ нь *санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, бодитой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 дахь заалтад “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

**2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

**2.12. Шилэн дансны мэдээлэл**

Булган сумын сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож 98,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

**2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна. Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардалд хааж бичиж байсан зөрчил илрээгүй болно.

**2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Булган сумын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Булган сумын сургууль 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан

бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

**СТ-1А**

## 3.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **19,064,722.17** | **26,992,722.17** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 19,064,722.17 | 26,992,722.17 |
| **351** | **Түүхий эд материал** | 224,700.00 | 224,700.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 224,700.00 | 224,700.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 18,335,022.17 | 26,263,022.17 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,883,203.17 | 20,040,203.17 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,416,800.00 | 1,416,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 35,019.00 | 4,806,019.00 |
| 35600 | Мал амьтад | 505,000.00 | 505,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,235,969,393.65** | **1,211,543,302.89** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,235,969,393.65 | 1,211,543,302.89 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,206,249,393.65 | 1,183,767,302.89 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 864,567,453.59 | 874,567,453.59 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 54,238,733.23 | 60,558,433.23 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (34,655,531.53) | (37,919,664.02) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 70,931,658.86 | 70,931,658.86 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (34,093,270.74) | (40,656,372.96) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 287,760,350.20 | 317,086,539.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,499,999.96) | (41,642,735.94) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 29,720,000.00 | 27,776,000.00 |
| 39301 | Програм хангамж | 12,646,000.00 | 12,646,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,926,000.00) | (4,870,000.00) |

| | | | |
|---|---|---|---|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,255,034,115.82** | **1,238,536,025.06** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,255,034,115.82** | **1,238,536,025.06** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,255,034,115.82 | 1,238,536,025.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 376,239,464.02 | 376,239,464.02 |
| 51101 | Өмч: - төрийн | 376,239,464.02 | 376,239,464.02 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 228,210,171.03 | 211,712,080.27 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 228,210,171.03 | 228,210,171.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (16,498,090.76) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 650,584,480.77 | 650,584,480.77 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,255,034,115.82** | **1,238,536,025.06** |

**СТ-2А**

## 3.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **584,151,812** | **402,881,189** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **296,323,912** | **17,084,000** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 296,323,912 | 17,084,000 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 296,323,912 | 17,084,000 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 296,323,912 | 17,084,000 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **287,827,900** | **385,797,189** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 277,943,900 | 330,971,000 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 277,943,900 | 330,971,000 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,884,000 | 29,326,189 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,454,000 | 29,326,189 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,430,000 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **320,126,938** | **419,379,280** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **320,126,938** | **419,379,280** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 300,313,729 | 410,957,580 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 198,454,532 | 257,191,300 |
| 210101 | Үндсэн цалин | 156,018,832 | 207,443,400 |
| 210102 | Нэмэгдэл | 11,300,500 | 27,613,800 |
| 210104 | Урамшуулал | 13,244,000 | 22,134,100 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17,891,200 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,828,200 | 33,063,600 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,079,400 | 22,482,800 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,794,900 | 2,644,900 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,587,700 | 2,116,400 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 396,800 | 529,100 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,969,400 | 5,290,400 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,763,725 | 20,500,000 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,783,445 | 7,400,138 |
| 210302 | Түлш, халаалт | 11,980,280 | 12,496,062 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,521,700 | 7,258,500 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,140,100 | 1,021,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,799,600 | 3,184,810 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 100,000 | 794,000 |
| 210404 | Ном, хэвлэл | 127,000 | 24,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,355,000 | 2,034,690 |
| **2105** | **Нормативт зардал** | 11,169,335 | 11,430,700 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 150,000 | 300,000 |
| 210502 | Хоол, хүнс | 9,718,335 | 9,976,400 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,301,000 | 1,154,300 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,958,000 | 4,565,000 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,958,000 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 294,000 | 1,245,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 294,000 | 1,245,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 450,000 | 3,551,500 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 270,000 | 3,371,500 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000 | 180,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 39,874,238 | 72,151,980 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 125,000 | 1,080,000 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 39,749,238 | 71,071,980 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 19,813,209 | 8,421,700 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,128,110 | 8,416,400 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,379,310 | 8,416,400 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 10,468,800 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 280,000 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 685,099 | 5,300 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 685,099 | 5,300 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **264,024,874.18** | **(16,498,090.76)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **264,024,874.18** | **(16,498,090.76)** |

**СТ-3А**

### 3.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **287,827,900** | **385,797,189** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **287,827,900** | **385,797,189** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 277,943,900 | 330,971,000 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 277,943,900 | 330,971,000 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,884,000 | 29,326,189 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,454,000 | 29,326,189 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,430,000 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **287,827,900** | **385,797,189** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **287,827,900** | **385,797,189** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **268,014,691** | **377,375,489** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 198,454,532 | 257,191,300 |
| 210101 | Үндсэн цалин | 156,018,832 | 207,443,400 |
| 210102 | Нэмэгдэл | 11,300,500 | 27,613,800 |
| 210104 | Урамшуулал | 13,244,000 | 22,134,100 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17,891,200 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,828,200 | 33,063,600 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,079,400 | 22,482,800 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,794,900 | 2,644,900 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,587,700 | 2,116,400 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 396,800 | 529,100 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,969,400 | 5,290,400 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,763,725 | 20,500,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,783,445 | 7,400,138 |
| 210302 | Түлш, халаалт | 11,980,280 | 12,496,062 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,011,400 | 9,367,500 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,140,100 | 1,021,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,799,600 | 3,184,810 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 100,000 | 794,000 |
| 210404 | Ном, хэвлэл | 127,000 | 200,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,844,700 | 3,967,690 |
| **2105** | **Нормативт зардал** | 11,169,335 | 14,290,700 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 150,000 | 300,000 |
| 210502 | Хоол, хүнс | 9,718,335 | 9,976,400 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,301,000 | 4,014,300 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,848,000 | 5,000,000 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,958,000 | - |
| 210604 | Урсгал засвар | 4,890,000 | 5,000,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 294,000 | 1,245,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 294,000 | 1,245,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 450,000 | 5,171,500 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 270,000 | 4,991,500 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000 | 180,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,195,500 | 31,545,889 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,195,500 | 1,080,000 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,813,209** | **8,421,700** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,128,110 | 8,416,400 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,379,310 | 8,416,400 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 10,468,800 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 280,000 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 685,099 | 5,300 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 685,099 | 5,300 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 0.00 |

**СТ-4А**

## 3.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 376,239,464.02 | 650,584,480.77 | 228,210,171.03 | 0.00 | 1,255,034,115.82 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **376,239,464.02** | **650,584,480.77** | **228,210,171.03** | **0.00** | **1,255,034,115.82** |
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **376,239,464.02** | **650,584,480.77** | **228,210,171.03** | **0.00** | **1,255,034,115.82** |
| **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **376,239,464.02** | **650,584,480.77** | **228,210,171.03** | **0.00** | **1,255,034,115.82** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **376,239,464.02** | **650,584,480.77** | **228,210,171.03** | **0.00** | **1,255,034,115.82** |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -16,498,090.76 | 0.00 | -16,498,090.76 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **376,239,464.02** | **650,584,480.77** | **211,712,080.27** | **0.00** | **1,238,536,025.06** |

ТГ

## 3.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 356,471,000 | 356,465,700 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 356,471,000 | 356,465,700 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 348,054,600 | 348,049,300 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 257,191,300 | 257,191,300 |
| 210101 | Үндсэн цалин | 207,443,400 | 207,443,400 |
| 210102 | Нэмэгдэл | 27,613,800 | 27,613,800 |
| 210104 | Урамшуулал | 22,134,100 | 22,134,100 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх** | | 33,063,600 |

| | | | |
|---|---|---|---|
| | **шимтгэл** | 33,063,600 | |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,482,800 | 22,482,800 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,644,900 | 2,644,900 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,116,400 | 2,116,400 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 529,100 | 529,100 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,290,400 | 5,290,400 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,500,000 | 20,500,000 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,000,000 | 7,400,138 |
| 210302 | Түлш, халаалт | 13,300,000 | 12,496,062 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,200,000 | 603,800 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,367,500 | 9,367,500 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,021,000 | 1,021,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,366,500 | 3,184,810 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,550,000 | 794,000 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000 | 200,000 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 200,000 | 200,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,030,000 | 3,967,690 |
| **2105** | **Нормативт зардал** | 14,290,700 | 14,290,700 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 300,000 | 300,000 |
| 210502 | Хоол, хүнс | 9,976,400 | 9,976,400 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,014,300 | 4,014,300 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,000,000 | 5,000,000 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000 | 5,000,000 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,250,000 | 1,245,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,250,000 | 1,245,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,171,500 | 5,171,500 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,991,500 | 4,991,500 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000 | 180,000 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,220,000 | 2,219,700 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,140,000 | 1,139,700 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,080,000 | 1,080,000 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,416,400 | 8,416,400 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,416,400 | 8,416,400 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,416,400 | 8,416,400 |